



Серверийн өрөөний эйр кондишныг худалдан авч суурилуулах ажлын техникийн шаардлага

Үндэслэл: Төв серверийн өрөөнд суурилагдсан холбоо, СКАДА, тоолуур, компьютер, серверийн тоног төхөөрөмжийн тэжээлээс хэрэглэх нийт хүчин чадал 17-19 кВт, байнгын дулаан ялгаруулалт өндөр, гадна агаар халах үед өрөөний дулаан 3-5 хэмээр нэмэгддэг тул найдвартай ажиллагааг хангах үүднээс шаардлага хангасан эйр кондишныг шинээр авч суурилуулах шаардлагатай. Серверийн өрөөний температур 17-22 хэм, агаарын чийгшил 40%-60% байх ёстой.

АТС-ын тусгаарлагдсан кабинетэд суурилагдсан 2 иж бүрдэл АТС, биллийн, бичлэгийн, мониторингийн 4 иж бүрдэл компьютерийн тэжээлээс хэрэглэх нийт хүчин чадал 3.5-4.0 кВт, байнгын дулаан ялгаруулалт өндөр, өрөөн дотор давхар ханаар тусгаарласан тул шаардлага хангасан эйр кондишныг шинээр авч суурилуулах шаардлагатай.

№	Байршуулах өрөө	Хэмжээ Урт/Өрг/Өнд	Эйр кондейшны хэлбэр маяг, тоо	Тайлбар
1	Төв серверийн өрөө /5-р давхар/	10.0/6.0/3.2м 192.0 кубм	1. Гадна байрлах компрессорын хэсэг: 2ш 2. Дотор таазанд байрлах вентиляторын хэсэг: 4ш 3. Гадна болон дотор байрлах хэсгийн хоорондын зай: 12м	*24 цагийн тасралтгүй ажиллагаатай, *алсын удирдлагатай, *гадна байрлах хэсэг -30 хэмд ажиллах, *Хүчин чадал:>5HP
2	Холбооны өрөөний АТС-ын кабинет /5 дасхар/	3.6/2.0/3.2м 23.04 кубм	1. Хананд суурилуулах зориулалттай 1 иж бүрдэл 2. Гадна болон дотор байрлах хэсгийн хоорондын зай: 6м	*24 цагийн тасралтгүй ажиллагаатай, *алсын удирдлагатай, *гадна байрлах хэсэг -30 хэмд ажиллах, *Хүчин чадал:>1.5HP

1. Техникийн үзүүлэлт: (1 иж бүрдэл: гадна хэсэг-1ш, дотор байрлах таазны-2ш)

- Хөргөх хүчин чадал: ->16.00кВт
- Халаах хүчин чадал: ->16.00кВт
- Хөргөх шингэн: -R410A
- Тэжээл тасалдах үед автоматаар өөрөө асдаг тохируулгатай байх,
- Чийгшил, температурын тохиргоотой байх
- Гэмтэл, доголдол гарсан үед дуут дохиолол өгдөг байх
- Дотор дуу чимээ 30дБ-ээс бага

Тайлбар: Кондишний дотор байрлах хэсгүүдийг серверийн өрөөний дүүжин таазаны 4 хэсэгт тэнцүү хувааж суурилуулна. Алсын болон суурин удирдлагаар нь халаах, хөргөх горим, агаар сэлгэх сэнсний хурд, цаг хугацаа тогтоох горим, температур тохируулах горим, асааж унтраах, үлээлтийн чиглэлийг өөрчлөх зэрэг

үйлдлийг гүйцэтгэдэг байх шаардлагатай. Бүтээгдэхүүн нь Европ стандартыг хангасан бөгөөд ашиглалтын аюулгүй байдлыг бүрэн хангасан байгаль орчинд ээлтэй байна.

2. Техникийн үзүүлэлт: (1 иж бүрдэл)

- Хөргөх хүчин чадал: $->4.00\text{кВт}$
- Халаах хүчин чадал: $->5.00\text{кВт}$
- Хөргөх шингэн: $-R410A$
- Тэжээл тасалдах үед автоматаар өөрөө асдаг тохируулгатай байх,
- Чийгшил, температурын тохиргоотой байх
- Гэмтэл, доголдол гарсан үед дохиолол өгдөг байх
- Дотор дуу чимээ 30дБ-ээс бага

Тайлбар: Кондишний дотор байрлах хэсгийг хананд суурилуулна. Алсын болон суурин удирдлагаар нь халаах, хөргөх горим, агаар сэлгэх сэнсний хурд, цаг хугацаа тогтоох горим, температур тохируулах горим, асааж унтраах зэрэг үйлдлийг гүйцэтгэдэг байх шаардлагатай. Бүтээгдэхүүн нь Европ стандартыг хангасан бөгөөд ашиглалтын аюулгүй байдлыг бүрэн хангасан байгаль орчинд ээлтэй байна.

Хянасан:

МТХА-ны дарга



Б.Давааням

МТХА-ны ахлах инженер



Д.Нацагдорж

Боловсруулсан:

МТХА-ны цахим хэрэгсэл
засварын инженер



П.Ганхуяг